



НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 05 өдөр

Дугаар A/29

Улаанбаатар хот

Дүүргийн ерөнхий эргүүл, жижүүр ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.4 дэх заалт, 78 дугаар зүйлийн 78.2, 78.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сар шинийн баярын өдрүүдэд дүүргийн хэмжээнд нийтийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд болон дулаан, цахилгааны болзошгүй гэмтэл, доголдол, сааталд хяналт тавьж, гарсан доголдол саатлыг шуурхай арилгуулж ажиллах ерөнхий эргүүл, жижүүрийн хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2. Баярын өдрүүдэд харуул, жижүүр, манаачийн ажлын хариуцлагын сонор сэрэмжийг дээшлүүлж хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулахыг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Ч. РАДНААБАЗАР

1126200079

Дүүргийн Засаг даргын 2018 оны
 02 дугаар сарын 02-ны өдрийн
 А/29 захирамжийн хавсралт



САР ШИНИЙН БАЯРЫН ӨДРҮҮДЭД ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ
 ЭРГҮҮЛ, ЖИЖҮҮРЭЭР АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Ерөнхий эргүүл	Ерөнхий жижүүр	Албан тушаал	Сар, өдөр	Хугацаа /цаг/
1	Хот төлөвлөлт, үйлдвэрлэл, ногоон хөгжлийн чиглэлийн төсөл хөтөлбөрийн удирдагч бөгөөд Засаг даргын орлогч С.Тунгалаг	О.Уранчимэг	Цэцэрлэгжүүлэлтийн албаны дарга	02/15	08.00-16.00
		П.Нарантуяа	Тохижилт, нийтийн үйлчилгээний хэлтсийн дарга	02/15	16.00-00.00
		Ц.Алтанцоож	Татварын хэлтсийн дарга	02/16	00.00-08.00
		Л.Байгаль	Эрүүл мэндийн нэгдлийн дарга	02/16	08.00-16.00
		Д.Ганзориг	“УБЦТС” ХК-ийн Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн дарга	02/16	16.00-00.00
		Ж.Ганзориг	Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга	02/17	00.00-08.00
2	Нийгэм, эдийн засгийн чиглэлийн төсөл хөтөлбөрийн удирдагч бөгөөд Засаг даргын орлогч Х.Анхбаяр	Н.Маналжав	“УБЦТС” ХК-ийн Налайх түгээх төвийн дарга	02/17	08.00-16.00
		Ц.Минжинхүү	“Налайхын Дулааны станц” ТӨХК	02/17	16.00-00.00
		Г.Баттөгс	Онцгой байдлын хэлтсийн дарга	02/18	00.00-08.00
		Н.Сумъяа	Цагдаагийн хэлтсийн дарга	02/18	08.00-16.00
		С.Баасанхүү	Соёлын ордны дарга	02/18	16.00-00.00